

БАТЛАВ:
ЦАГААНДЭЛГЭР СУМЫН
ЗДТГ-ЫН ДАРГА: А.СОЛОНГО
ТУ 31364 № 10539 820020006



ДУНДГОВЬ АЙМГИЙН ЦАГААНДЭЛГЭР СУМЫН
“МАЛ НЯДАЛГААНЫ ЦЭГ” -ИЙН
АЖЛЫН ГЭРЭЭ

2022 оны 06 сарын 06-ны өдөр

№ ДУГАЦДСЗДТГ/202201007

Хараат

Нэг талаас (Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Засаг даргын тамгын газар) /цаашид “Захиалагч” гэх/.

Нөгөө талаас (“Чандмань” бүлэг) /цаашид “Гүйцэтгэгч” гэх/ дараах зүйлсийг харилцан тохиролцож 2022 оны 06 сарын 06-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид гэрээ гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдуулан захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг хариуцлагыг тогтооход тоног төхөөрөмж сууринуулахтай холбогдон захиалагч гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь ДУНДГОВЬ АЙМГИЙН ЦАГААНДЭЛГЭР СУМЫН МАЛ НЯДАЛГААНЫ ЦЭГИЙН (ДУГАЦДСЗДТГ/202201007) ажлыг цаашид “ажил” гэх /9,636,.000/ есөн сая зургаан зуун гучин зургаан мянган төгрөг цаашид “гэрээний үнэ” гэх гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно. Санхүүжилтийг ажлын 80% хийсний дараа эхний ээлжинд 80%, ажил дууссаны дараа 20% хийнэ. Ажлаа комисст хүлээлгэн өгсний дараа үлдэгдлийг ажлын 5 хоногийн дотор санхүүжилт хийнэ. Шилжүүлэх данс: 5463011645

3. Гэрээний нийт үнэ 9.636.000 төгрөг үүнээс Орон нутгийн хөгжлийн сан 2022 онд 9.636.000 төгрөг

4. Гүйцэтгэгч нь ДУНДГОВЬ АЙМГИЙН ЦАГААНДЭЛГЭР СУМЫН МАЛ НЯДАЛГААНЫ ЦЭГИЙН ажлыг 2022 оны 06 дугаар сарын 07 -ноос 2022 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор гүйцэтгэнэ.

5. Дор дурьдсан баримт бичиг нь гэрээний хэсэг болно. /цаашид гэрээний баримт бичиг гэх/ Үүнд:

5.1 Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

5.2 Бусад шаардлагатай баримт бичиг

5.3 Гэрээний тусгай нөхцөл

5.4 Гэрээний ерөнхий нөхцөл

5.5 Техникийн тодорхойлолт

5.6 Зураг

5.7 Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь

5.8 Санхүүжилтийн хуваарь

5.9 Ажил гүйцэтгэх хуваарь


Гэрээ нь энд дурьдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний

- баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.
6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх үүрэг хүлээнэ.
 7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл болзод нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил гологдол арилгах үүрэг хариуцлагыг хүлээнэ.
 8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг харицлага хүлээнэ.
 9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.
 10. Ажлыг батлагдсан зургийн дагуу гүйцэтгэх ба гэрээт хугацаандаа ашиглалтад өгөөгүй бол хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үнийн дүнгийн 3 хувиар алданги ногдуулна. Гэхдээ алданги хүлээнсээр үргийн гүйцэтгэлээс чөлөөлөгдөхгүй.
 11. Захиалагч болон гүйцэтгэгчийн үйл ажиллагаанаас үл хамааран ажил гүйцэтгэх хугацаанд саатал гарсан тохиолдолд хамтран тохиролцож, ажлын графикт зохицуулалт хийсний үндсэн дээр ажил дуусгах хугацаанд өөрчлөлт оруулж болно.

Маргаан шийдвэрлэх

12. Энэхүү гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.
13. Хэрвээ санал зөрөлдөөнийг хэлэлцэн шийдвэрлэж чадахгүй бол хууль тогтоомжид заасны дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.
14. Энэхүү гэрээг 3 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:



ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

“ЧАНДМАНЬ” БҮЛГИЙН ГИШҮҮН
...../T.TÖR-ERDÉNÉ /